

**"МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН  
ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ" УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ АНХНЫ  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН  
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 5 дугаар  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын  
гишүүн С.Дэмбэрэл

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2015 оны 5 дугаар сарын 08-ны өдөр хэлэлцээд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Уг асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2015 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж байна.


Үндсэн чиглэлийн төслийг Байнгын хороогоор хэлэлцэх явцад Улсын Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд, Ц.Дашдорж, С.Дэмбэрэл Д.Лүндээжанцан, Н.Энхболд нар "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтын 20 дугаар зорилтод "Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, парламентын тогтолцооны шинэчлэлийг хийх"; "Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхой болгож давхардлыг арилгах, бодлогын нэгдмэл чанарыг хангах чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах" гэсэн арга хэмжээ нэмэх; Улсын Их Хурлын гишүүн А.Бакей "Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, хэлэлцэх, хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох"; "Засаглал, эрх зүйн шинэчлэлийн бодлогын хүрээнд өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийг хэлэлцэн батлах" зэрэг арга хэмжээг нэмэх саналуудыг гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



**А.БАКЕЙ**

**"МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН  
ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ" УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААР  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО ДЭМЖСЭН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ  
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:**

1. Төслийн 20 дугаар зорилтод "Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж парламентын тогтолцооны шинэчлэлийг хийх" гэсэн арга хэмжээ нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд, Ц.Дашдорж,  
Д.Лүндээжанцан, Н.Энхболд**

2. Төслийн 20 дугаар зорилтод "Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхой болгож давхардлыг арилгах, бодлогын нэгдмэл чанарыг хангах чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах" гэсэн арга хэмжээ нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд, Ц.Дашдорж,  
С.Дэмбэрэл Д.Лүндээжанцан, Н.Энхболд**

3. Төслийн 20 дугаар зорилтод "Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, хэлэлцэх, хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох" гэсэн арга хэмжээ нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн А.Бакей**

4. Төслийн 20 дугаар зорилтод "Засаглал, эрх зүйн шинэчлэлийн бодлогын хүрээнд өргөн мэдүүлсэн болон өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийг хэлэлцэн батлах" гэсэн арга хэмжээ нэмэх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн А.Бакей**

---ooOoo---